



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар

12/01

Пионер толгой

Хайгуулын тусгай зөвшөөрөл
олгохоос татгалзах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 12 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газраас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой гэж үзсэн манай сумын Цэнгэл 1 дүгээр багийн нутаг 4859,9 га талбайд “Урд гэртийн булаг”, “Хойд гэртийн булаг”, “Эмгэний булаг”, “Авхайн булаг”, “Бортолгойн булаг”, “Цагаан толгойн булаг”, “Мөрөнгийн дээд булаг”, “Мөрөнгийн доод булаг”, “Асгатын булаг”, “Гуагийн булаг”, “Шинэбулаг”, “Баянгийн гол”, “Баянгийн булаг” зэрэг 14 булаг шанд, түүх соёлын дурасгалт болон байгалийн өвөрмөц тогтоц бүхий “Гурванбулаг хайрхан”, “Ноён хайрхан”, “Морин мөртийн хүний болон адууны туурайн мөр, хадны сүг зураг”, түргийн үеийн буган чулуун хөшөө, “Эмгэний гурван цохио” зэрэг газрууд, “Ацийн цагаан мухар”, “Аарагийн сархиа” зэрэг эхсийн онгон, хойлог, ахууна зэрэг ховор шувуу, аргал, янгир, шилүүс, ирвэс, тарвага зэрэг ховор болон нэн ховор ан амьтан, ардын уламжлалт эмчилгээний алтан гагнуур, вансэмбэрүү зэрэг 10 гаруй төрлийн эмийн ургамал 7 суурийн өвөлжөө, хаваржаа шууд нөлөөлөлд, нөлөөллийн бүсэд 10 суурийн өвөлжөө, хаваржаа нийт 40 гаруй өрхийн 14477 толгой малын бэлчээрийг хамаарч байгаа бөгөөд 2022 оны бэлчээрийн мониторинг судалгаагаар бэлчээрийн хүрэлцээ 70 хувь хэтэрсэн, мал сүргийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол өсөж бэлчээрийн хомсдол үүсэж байгаа зэрэг шалтааны улмаас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй гэж үзсүгэй.

2. Тогтоол, тэмдэглэлийг 4 дүгээр сарын 03-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга (Б.Гантулга), иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Алтанцэцэг) нарт даалгасугай.

ДАРГА  Ч.ЭРДЭНЭ-ОЧИР

648801005